



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/1142

Улаанбаатар хот

Нийслэлд болсон үерийн хор уршгийг
арилгахад дүүргээс тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгийн тухай хуулийн 32.1.1, 32.1.6 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/806 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах, үерийн хор уршгийг арилгах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хүн хүч, техник хэрэгслээр хангаж оролцохыг “Илч-Орд” ОНӨААТҮГ (Д.Гантулга), “Багахангай” тохижилт ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа), Багахангай Гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ (Ч.Батхуяг) нарт тус тус үүрэг болгосугай.

2.Үерийн хор уршгийг арилгахад шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах 3,652,500 (Гурван сая зургаан зуун тавин хоёр сая таван зуун) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 07 дүгээр сарын 10 ны өдрийн
А.1.12 дугаар захирамжийн хавсралт



ҮЕРИЙН ХОР УРШГИЙГ АРИЛГАХАД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

| № | Бараа материалын нэр | | Тоо ширхэг | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|----------|----------------------|------|------------|-------------|----------------|-----------|
| 1 | Шатахуун | А-92 | 200 | л | 2400 | 480,000 |
| | | Түлш | 600 | л | 3500 | 2,100,000 |
| 2 | Хоол (өдөрт 3 хоол) | | 35 | хүн | 10500 | 1,102,500 |
| Нийт дүн | | | | | | 3,682,500 |